



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/120

Хархорин сум

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Малчдад тэжээл тариалах тариалангийн талбайг ашиглуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100233

Хархорин сумын Засаг даргын 2024  
...06... дугаар сарын 18...ны өдрийн  
А/120 дугаар захирамжийн хавсралт

## **МАЛЧДАД ТЭЖЭЭЛ ТАРИАЛАХ ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙГ АШИГЛУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Малын тэжээлийн ургамал тариалах тариалангийн талбайг малчдад ашиглуулах, үрийг хувиарлах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

### **Хоёр. Засаг даргын Тамгын газрын эрх, үүрэг**

2.1. Тариалангийн талбай нь Засаг даргын Тамгын газрын эзэмшил бөгөөд ашиглагч нь тухайн сумын хөдөөгийн багийн малчин өрх байна.

2.2. Тариалангийн талбайг ашиглуулах малчдын нэрсийг тариалалтаас 20 хоногийн өмнө тухайн багийн Засаг дарга гаргаж, Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь малчин өрхийн А данстай тулган баталгаажуулна.

2.3. Малын тоо толгойн албан татвараа төлөөгүй малчин өрх, тариалангийн талбайд мал тэжээвэр амьтан оруулсан зөрчилд холбогдож байсан малчин өрхийг баталгаажуулахыг хориглоно.

2.4. Тариалах үрийг баг бүрт жигд хувиарлаж, Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь Засаг даргын Тамгын газрын няравыг байлцуулан багийн Засаг дарга нарт хүлээлгэн өгнө.

2.5. Тариалангийн талбайн ашиглалтад Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн байнгын хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллана.

### **Гурав. Багийн Засаг дарга нарын эрх, үүрэг**

3.1. Тариалангийн талбайг ашиглуулах малчдын нэрсийг тариалалтаас 20 хоногийн өмнө Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэнд гаргаж өгнө.

3.2. Тухайн жилийн малын тоо толгойн албан татвараа төлөөгүй малчин өрхийг хамруулахыг хориглоно.

3.3. Хашааг гэрээгээр ашиглаж, бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээг өөрийн багийн малчдад хариуцуулж өгнө.

3.4. Өөрийн багт хуваарилагдсан тариалангийн талбайд тариалалт хийх ажлыг удирдан зохион байгуулна.

3.5. Зөвхөн өөрийн багийн жилийн дөрвөн улиралд мал малладаг малчдыг тариалалт хийлгэнэ.

3.6.Хаврын тариалалт, намрын ургац хураалтын тайланг Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэнд тухай бүр ирүүлнэ.

### **Дөрөв. Тариалангийн талбай ашиглагчийн эрх, үүрэг**

4.1.Малын тэжээлийн ургамал тариалах хүсэлтээ тариалалт эхлэхээс 30 хоногийн өмнө харъяа багийн Засаг даргадаа ирүүлнэ.

4.2.Хүсэлт ирүүлэхээс өмнө малын тоо толгойн албан татварыг бүрэн төлсөн байна.

4.3.Багийн зохион байгуулалтад орж, заасан тариалангийн талбайд тэжээлийн ургамал тариална.

4.4.Тэжээлийн ургамал тариалахад шаардагдах шатах, тослох материал, сэлбэг хэрэгслэл, засвар, ажил үйлчилгээний зардлыг хариуцна.

4.5.Хашааг тогтмол засварлаж бүрэн бүтэн байдлыг хариуцаж, мал тэжээвэр амьтан орж, талхлагдахаас хамгаалах арга хэмжээ авна.

4.6.Хураан авсан ургацыг тариалалт хийсэн малчид тэнцүү хуваан авч, өвс тэжээлийн нөөц бүрдүүлнэ.

### **Тав. Бусад**

5.1.Тэжээлийн талбайн тоног төхөөрөмж, хашааг эвдэж хэмхлэх, алдаж үрэгдүүлэх зэргээр орон нутгийн өмчид хохирол учруулбал тухайн хохирлыг тариалангийн талбайг ашиглагч тал зах зээлийн ханшаар тооцож хохиролгүй болгоно.